

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Төслийн байршил:.....	3
1.3. Уурхайн хүчин чадал, ажлын горим, ашиглалтын хугацаа	5
1.3.1. Ил уурхайн календарчилсан төлөвлөгөө	5
1.3.2. Уурхайн ажиллах горим	6
1.4. Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд.....	6
1.5. Баяжуулах үйлдвэрийн технологийн горим	7
1.5.1. Хүдэр бутлалт.....	7
1.5.2. Хүдэр баяжуулалт	7
1.5.3. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадлын тооцоо	8
1.5.4. Баяжуулах үйлдвэрийн усан хангамж.....	8
1.6. Дэд бүтэц	9
1.6.1. Цахилгаан хангамж	9
1.6.2. Газар ашиглалт	9
1.6.3. Төслийн усан хангамж.....	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	10
2.1. Газрын гадаргуу	10
2.2. Уур амьсгалын горим	10
2.3. Хөрсөн бүрхэвч	10
2.4. Ургамлан бүрхэвч	12
2.5. Амьтны аймаг	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	15
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
4.2. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө	23
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	25
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	25
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	27
4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	31
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32
4.10. Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.....	33

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжих талбайн солбилцол	3
Хүснэгт 2.	Ил уурхайн календарь төлөвлөгөө	5
Хүснэгт 3.	Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног	6
Хүснэгт 4.	Ил уурхайн үндсэн хэмжээсүүд	6
Хүснэгт 5.	Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим	8
Хүснэгт 6.	Баяжуулах үйлдвэрийн ус зарцуулалтын тооцоо	8
Хүснэгт 7.	Усны нийт хэрэглээний тооцоо	9
Хүснэгт 8.	Хөрсний зүсэлтийн газарзүйн байршил, солбицол, өндөршил	11
Хүснэгт 9.	Хөрсний хүнд металлын агууламжийг хүлцэх хэмжээтэй харьцуулсан хэмжээ	12
Хүснэгт 10.	Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	15
Хүснэгт 11.	Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	17
Хүснэгт 12.	Бомт-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	19
Хүснэгт 13.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 14.	Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 15.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	25
Хүснэгт 16.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	25
Хүснэгт 17.	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	26
Хүснэгт 18.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 19.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 20.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	31
Хүснэгт 21.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	32
Хүснэгт 22.	Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	33

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1.	Төсөл хэрэгжих талбайн байршил	4
Зураг 2.	Ил уурхайн календарчилсан төлөвлөгөө	5
Зураг 3.	Гэрлийн оптик ойлтоор ялгах мэдрэгчид суурилсан технологи	7
Зураг 4.	Талбайн хад чулуутай, өндөрлөг, толгодын чулуурхаг нимгэн цайвар хүрэн хөрс	11
Зураг 5.	Талын бэсрэг уул, толгодын ургамалжлын бүлгэмдэл	13
Зураг 6.	Хуурай хээрийн ургамалжлын бүлгэмдэл	13

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Цагаан дэлт” хайлуур жонш олборлох төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Саншайн энерги майнинг” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019097705, Регистрийн дугаар: 8369933, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: MV-022599
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Эко интернэйшнл тауэр” 15 давхарт. Утас: 77189988


1.2. Төслийн байршил:

“Цагаан дэлт” хайлуур жоншны орд нь Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос урагш 370 км-т, Гурвансайхан сумаас урд зүгт 30 км-т байрлана.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

№	Урт	Өргөрөг
1	107°4'2.4"	45°15'11.16"
2	107°4'2.4"	45°11'3.5"
3	107°5'41"	45°11'3.5"
4	107°5'41"	45°7'40"
5	107°1'7"	45°7'40"
6	107°1'7"	45°10'34"
7	107°3'37.8"	45°10'34"
8	107°3'37.8"	45°13'51.5"
9	107°0'1.48"	45°13'51.5"
10	107°0'1.48"	45°15'11.16"

Дээрх солбицолоор нийт 5029.70 га талбайг хамарна.



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.3. Уурхайн хүчин чадал, ажлын горим, ашиглалтын хугацаа

Ил уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаврыг үндэслэн жилд 100.0 мян.тн хүдэр олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна.

Ил уурхайн ажиллах жилийг тодорхойлбол:

$$T = \frac{Q_a}{A_{\text{ж}}} = \frac{167901.1}{100000} = 1.68 \approx 2$$

Энд:


Q_a - Ашиглалтын нөөц /тн/

$A_{\text{ж}}$ - Уурхайн жилийн хүчин чадал /тн/

1.3.1. Ил уурхайн календарчилсан төлөвлөгөө

Хүснэгт 2. Ил уурхайн календарь төлөвлөгөө

№	Ашиглалтын жил	Хүдэр	Агуулга	Эрдэс	Хөрс	Хөрс хуулалтын итгэлцүүр
		мян.тн	%	мян.тн	мян.м ³	м ³ /тн
1	I жил	67.9	54.46	36.98	160.0	2.36
2	II жил	100.0	59.69	59.69	296.0	2.96
3	Нийт	167.9	57.58	96.67	456.0	2.72



Зураг 2. Ил уурхайн календарчилсан төлөвлөгөө

I жил: Ашиглалтын 1-р жилд I ба II хүдрийн биетэд ашиглалт явуулж, 1217 м-ийн түвшин хүртэл ашиглана. I хүдрийн биетийг бүрэн ашиглаж дуусгах ба II хүдрийн биетийн II-B-1, II-B-3, II-B-3, II-B-4, II-C-5 блокуудад ашиглалт явуулна. 1-р жилд нийт 160.0 мян.м³ хөрс хуулж, 67.9 мян.тн хүдэр олборлоно. Уурхайгаас хуулсан хөрсийг уурхайн урд талд 75 м-ийн зайд, дунджаар 11 м-ийн өндөртэй, сийрэгжилт тооцсоноор 208.0 мян.м³ эзэлхүүнтэй овоолго үүсгэнэ.

II жил: Ашиглалтын 2-р жилд II ба III хүдрийн биетэд ашиглалт явуулж бүрэн олборлож дуусгана. 1187 м-ийн түвшин хүртэл ашиглана. Ашиглалтын 2-р жилд 296.0 мян.м³ хөрс хуулж,

100.0 мян.тн хүдэр олборлоно. Уурхайгаас хуулсан хөрсийг уурхайн урд талд 75 м-ийн зайд, дунджаар 13 м-ийн өндөртэй, сийрэгжилт тооцсоноор 592.8 мян.м³ эзлэхүүнтэй овоолго үүсгэнэ.

1.3.2. Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилд 240 хоног, хоногт 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төсөлд тусгав.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	15
3	Бэлтгэл ажлын хоног	хоног	15
4	Өвлийн улирлын зогсолт	хоног	125
5	Уурхайн ажиллах хоног	хоног	210
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
7	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Ил уурхайн хажуугийн өнцөг	градус	28-50
2	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр	м	5
3	Хүдэр олборлолтын ажлын доголын өндөр	м	5
4	Доголын хажуугийн өнцөг	градус	65
5	Ажлын доголын аюулгүйн тавцангийн өргөн	м	3.5
6	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	20
7	Ажлын талбайн өргөн	м	25
8	Ил уурхайн гүн	м	50
9	Ил уурхайн амсрын урт	м	210
10	Ил уурхайн амсрын өргөн	м	150

Дээр авсан хэмжигдэхүүнүүдийг тусгасан дэвсгэр болон босоо, хөдлөн зүсэлт зургууд дээр ил уурхайг байгуулж, ил уурхайн хүрэн дэх хүдэр болон хөрс хуулалтын хэмжээг тодорхойлсон.

1.4. Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг худалдан авч ажиллуулахаар энэхүү төсөлд тусгалаа. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана.

- ✓ 3 м³-ийн утгуурын багтаамжтай Hyundai фирмийн R520LC маркийн урвуу утгуурт экскаватор;
- ✓ 40 тн даацтай Yutong фирмийн YTK-63 маркийн автосамосвалууд;
- ✓ 110-203 мм-ийн диаметртэй ROC-L8 маркийн өрмийн машин;
- ✓ 3 м³ -н утгуурын багтаамжтай SDLG-933 маркийн утгуурт ачигч;
- ✓ 120 кВт хүчин чадалтай SD-16 маркийн бульдозер;
- ✓ XCMG фирмийн GR-215 маркийн грейдер;
- ✓ Туслах машин механизм (үйлчилгээний машинууд г.м.).

1.5. Баяжуулах үйлдвэрийн технологийн горим


Баяжуулах үйлдвэр нь хүдэр хүлээн авах талбай, бутлан ангилах хэсэг, бүхэллэг жоншийг гар аргаар ялгах хэсэг, тусгай аргаар баяжуулах хэсэг, эргэлтийн усны сан, хаягдал чулууны овоолго, хяналт шинжилгээний лаборатори, баяжмал ачих, тээвэрлэх талбай зэргээс бүрдэнэ.

1.5.1. Хүдэр бутлалт

Уурхайгаас олборлох хүдрийн ширхэглэл 0-500 мм ба гар аргаар ялгахад хүндрэлтэй, овор хэмжээ ихтэй хүдрийг бутлах зорилгоор 250 мм-ийн нүхтэй тороор шигшиж 250 мм-ээс том ширхэглэлтэй хүдрийг 1-р шатны бутлуурт бутална. Бүхэллэг жонш болон хаягдал чулууг гар аргаар ялгасны дараагаар үлдэх хүдрийг 2-р шатны шигшүүрт 0-6 мм, 6-50 мм, +50 мм гэсэн ангиллаар шигшиж +50 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг 2-р шатны бутлуурт гүйцээн бутална. 6-50 мм-ийн ширхэглэлтэй хэсгийг 6-25 мм болон 25-50 мм ширхэглэлээр нойтон орчинд шигшиж гэрлээр ялгах баяжуулах төхөөрөмжид тэжээл болгон өгнө.

1.5.2. Хүдэр баяжуулалт

Анхдагч хүдрээс ФК-85 маркийн бүхэллэг жонш болон хаягдал хар чулууг гар аргаар ялгаж, үлдэх хүдрийг бутлан ангилна. Бутлан ангилах хэсгээс гарах 6-25 мм болон 25-50 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг тус тусад нь 1 шатны гэрлийн оптик ойлтоор ялгах мэдрэгчид суурилсан технологиор баяжуулан ФК-85 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэнэ. Ялгах төхөөрөмжөөс гарах хаягдал болон 0-6 мм-ийн ширхэглэлтэй нунтаг хүдрийг хольж, флотацийн аргаар баяжуулах дотоодын үйлдвэрүүдэд худалдана.



Зураг 3. Гэрлийн оптик ойлтоор ялгах мэдрэгчид суурилсан технологи

1.5.3. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадалын тооцоо

Уурхайгаас хүдэр олборлох хүчин чадал 67.9-100.0 мян.тн ба баяжуулах үйлдвэр болон гар аргаар жонш ялгах ажилчдыг дулааны улиралд буюу 4-11 сар хүртэл 240 хоног ажиллахаар төлөвлөсөн. Дараах хүснэгтэд баяжуулах үйлдвэрийн ажиллах горимыг үзүүлэв.

Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

№	Ажиллах горим	Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	Нийт
1	Жилд ажиллах хоног	хоног	151	222	93
2	Жилд ажиллах цаг	цаг	1810.7	2667	1119
3	Хоногт ажиллах цаг	цаг	12	12	12
4	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	1	1	1
5	Ээлжид ажиллах цаг	цаг	12	12	12
6	Техникийн ажлын норм	%	75	75	75
7	Цагийн хүчин чадал	тн/цаг	50.0	50.0	50.0
8	Хоногийн хүчин чадал	тн/хоног	450.0	450.0	450.0
9	Жилийн хүчин чадал	тн/жил	67901.1	100000.0	167901.1

1.5.4. Баяжуулах үйлдвэрийн усан хангамж

Баяжуулах үйлдвэрийн нийт усны хэрэглээ цагт 22.2 м³, үүнээс шинээр сэлбэх цэвэр усны хэрэглээ 2.1 м³ буюу 0.6л/с—ээс багагүй ундаргатай байх шаардлагатай байна. Ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дотор компанийн өөрийн хөрөнгөөр 1 ширхэг гүний худаг гаргаж баяжуулах үйлдвэрийн шаардлагатай усыг гүний худгаас хангана. Нийт хэрэгцээт усны 90.5%-ийг эргэлтийн усан хангамжаар шийдвэрлэх бөгөөд үлдсэн 9.5%-ийг цэвэр усаар хангахаар тооцоолсон. Баяжуулах үйлдвэрийн нийт усны хэрэглээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн ус зарцуулалтын тооцоо

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэглээ	м ³ /цаг	22.2
2	Цэвэршүүлэн буцаан ашиглах усны хэрэглээ	м ³ /цаг	20.1
3	Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усны дахин ашиглалт	%	90.51
4	1 тн хүдэр баяжуулахад хэрэглэгдэх усны хэмжээ	м ³ /цаг	0.4
5	Жилд хэрэглэх нийт усны хэмжээ	мян.м ³ /жил	44.4
6	Жилд хэрэглэх эргэлтийн усны хэмжээ	мян.м ³ /жил	40.1
7	Шинээр зарцуулах цэвэр усны хэмжээ	м ³ /цаг	2.10
8		м ³ /хоног	20.0
9		мян.м ³ /жил	4.2
10	Баяжуулах үйлдвэрийн хэрэгцээтэй усны ундарга	л/сек	0.6

Эргэлтийн усны сан нь технологийн ус, тоос дарах болон бусад шаардлагатай усны хэрэглээг хангах бөгөөд эргэлтийн усны сан, ус дамжуулах хоолой, даралтын насос зэргээс бүрдэнэ. Эргэлтийн ус дамжуулах насосын станцын гарах аманд урсацын хэмжээ, даралтыг шалгах хэмжүүр суурилуулна.

1.6. Дэд бүтэц

1.6.1. Цахилгаан хангамж

Тус ордыг төвлөрсөн цахилгаан хамгамжаас хангах боломжтой төв газар нь Гурвансайхан сум бөгөөд зүүн хойд зүгт 30 км зайд оршино. Тус ордод 2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлаар нийт 4-н хүдрийн биет тогтоогдсоноос энэхүү төслийн хүрээнд I, II, III хүдрийн биетүүдийг ил уурхайн аргаар 2 жилийн хугацаанд ашиглах төсөл тул 30 км зайд 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж эрчим хүчээр хангах нь хөрөнгө оруулалтын хувьд ашиггүй байгаа тул дизель цахилгаан үүсгүүрээс эрчим хүчээр хангахаар тооцсон.

Уурхайн цахилгааны бүрэн чадлыг үндэслэн 140 кВт, 175 кВА-н хүчин чадал бүхий BF-C175 маркийн дизель цахилгаан үүсгүүрийг ашиглахаар төсөлд тусгаж байна.

1.6.2. Газар ашиглалт

Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумдын нутаг дэвсгэрт орших “Саншайн Энержи майнинг” ХХК-ийн MV-022599 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Цагаан дэлт” хайлуур жонш ашиглах төслийн талбайд ашиглалтын 5 жилд ил уурхайн ухааш 2.27 га, хөрсний овоолго 4.29 га, шимт хөрсний овоолго 0.48 га, хөрсний түр овоолгын талбай 0.5 га, уурхайн тосгон захиргаа 0.086 га, засварын газар 0.036 га, шатахуун түгээх станц 0.007 га тэсрэх материалын агуулах 1.29 га, ногоон байгууламжийн талбай 0.2 га, сайжруулсан шороон зам (урьдчилсан байдлаар кемпээс тэсрэх материалын агуулга болон бусад объект хүртэлт нийт урт 1500м, өргөн 10м) – 1.1 га буюу нийт **10.26** га талбай байна.

1.6.3. Төслийн усан хангамж

Төслийн талбай нь ус зүйн нь хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Таац голын сав газарт хамаарна.

Хүснэгт 7. Усны нийт хэрэглээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Усны зарцуулалт			Усны эх үүсвэр
		м³/жил	м³/хон	л/сек	
1	Унд, ахуйн усны хэрэгцээ	3,888.0	16.2	0.19	Хурын усыг хуримтлуулах, уурхайн шүүрлийн ус болон өөрийн эзэмшлийн гүний худгаас /ундарга: 4.0 л/сек /хангана.
2	Технологийн усны хэрэглээ	72,405.0	1,575.0	5.47	
3	Зам талбайн усалгаа	9,900.0	66.0	0.76	
4	Ногоон байгууламжийн усалгаа	300.0	22.0	0.253	
5	Биологийн нөхөн сэргээлт	577.12	19.24	0.22	
Нийт		86,493.0	1698.44	6.893	

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Газрын гадаргуу

Намхан уул, гүвээ толгодорхог хэрчигдэл багатай өргөн хөндий хоолой хосолсон онцлогтой. Дүүргийн үнэмлэхүй өндөр нь 1157.0 м (Хөх өндөр)-өөс 1127.0 м-т хэлбэлздэг ба харьцангуй өндөршил нь 30-50 м байдаг. Дүүргийн усан хагалбар болох нам уулс, гүвээ толгод нь өргөргийн дагуу чиглэлтэй сунаж тогтсон.

Дээрх бэсрэг уулс нь голчлон сиенит, занар, шохойн чулуунаас тогтох бөгөөд орой нь тэгш хавтгай, бөмбөгөр хэлбэртэй хажуу нь элэгдэж хадан гарш, мөргөцөг үүсгэх нь элбэг. Өндөрлөгүүдийн хажуу бэлээр хадан гарш муутай тэгш толгод элбэг тохиолдоно.

Гадаргуугийн ийм орчинд элэгдэл идэгдлийн үйл ажиллагаа сул явагдаж усан сүлжээ муу хөгжсөн, бэсрэг уулсаас эх авсан хуурай сайрууд нь хэрчигдэл багатай, хэдэн зуун метрээс хэдэн км үргэлжилж хоолой хөндийн тэгш гадаргад шилжинэ. Хуурай гол сайрын өргөн хэдэн арван метр-ээс хэдэн 100 м хүрэх ба голын дэнж муу хөгжсөн. Зарим хэсэгт хуурай сайр нь уужирч хоолой хөндий үүсгэнэ.

Одоогоор төслийн үйл ажиллагаа эхлээгүй, байгалийн унаган төрхөөрөө байна. Газрын гадаргад хужир мараа, намаг ажиглагдаагүй, газар ашиглалтын аюулгүй байдал зөрчил үүсээгүй байна.

2.2. Уур амьсгалын горим

Дундговь аймаг нь 74.69 км.кв талбайтай, далайн түвшнээс дээш 1100-1350 метрт өргөгдсөн, Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт, говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөрт орших Дэлгэрхангай уул юм. Дундговь аймагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй бөгөөд боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бүхий ухаа гүвээрхэг тэгшивтэр нутагт хамаарна.

Уур амьсгалын мужлалын хувьд хойд хэсгээрээ хуурайдуу сэрүүвтэр хүйтэн; өмнөд хэсгээрээ хуурай дулаавтар хүйтэвтэр; нэн хуурай, дулаан хүйтэвтэр бүсүүдэд оршдог. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай, өргөргийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг, хуурай агаартай хөрснөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учраас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг.

Дундговь аймгийн дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур $+1.1...+3.6^{\circ}\text{C}$ бөгөөд өвлийн улиралд $-20.8...-14.0^{\circ}\text{C}$, хаврын улиралд $+2.3...+4.9^{\circ}\text{C}$, зуны улиралд $+17.8...+19.9^{\circ}\text{C}$, намрын улиралд $-0.6...3.4^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ.

Хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур $-16.7...-19.6^{\circ}\text{C}$ байхад агаарын үнэмлэхүй хамгийн бага -39.7°C 1981 онд Сайхан-Овоо өртөөнд ажиглагдсан байдаг. Хамгийн дулаан 7 дугаар сард агаарын температур $19.9...22.3^{\circ}\text{C}$ байхад агаарын үнэмлэхүй их температур 41.3°C Гурвансайхан өртөөн дээр 1999 онд ажиглагдсан байдаг байна.

2.3. Хөрсөн бүрхэвч

Дундговь аймгийн Гурвансайхан ба Өлзийт сумдын нутагт орших “Саншайн Энержи Майнинг” ХХК-ийн хайлуур жонш олборлох 5030 га талбайд хөрсний төлөв байдал, экологи-эдийн засгийн үнэлгээний судалгааг 2025 оны 04 сарын 24-нд хийсэн. Монгол орны газарзүйн

байршлын хувьд дээрх талбай **хуурай хээрийн бүс** нутагт хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл, **тал хээр, цөлөрхөг хээрийн зааг нутаг** байна.

Хүснэгт 8. Хөрсний зүсэлтийн газарзүйн байршил, солбицол, өндөршил

Солбицлын цэг, №	Хойд өргөрөг	Зүүн уртраг	ДТД, м
Талбайн солбицол			
Хөрсний зүсэлт h-1	45°14'53.07"N	107° 0'16.67"E	1220
h-2	45°14'24.79"N	107° 2'23.02"E	1185
h-3	45°10'5.24"N	107° 4'39.29"E	1148
h-4	45°10'5.24"N	107° 4'39.29"E	1205
h-5	45° 8'56.94"N	107° 4'9.26"E	1243
h-6	45° 8'14.42"N	107° 2'45.39"E	1233
h-7	45° 9'58.25"N	107° 2'8.36"E	1165
Таних тэмдэг:		h1-7 хөрсний зүсэлт, түүний дугаар	



Гурвансайхан сумын нутаг, талбайн хойд хэсэг, 105 га (Зураг 1)



Өлзийт сумын нутаг, талбайн урд хэсэг 2470 га Зүсэлт 5 (Зураг 1)

Зураг 4. Талбайн хад чулуутай, өндөрлөг, толгодын чулуурхаг нимгэн цайвар хүрэн хөрс

Байгалийн жамаар байгаа цайвар хүрэн хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламжийг зүсэлт 5-ын 0-20 см (толгодын чулуурхаг нимгэн цайвар хүрэн хөрс), зүсэлт 7-гийн 22-32 см, зүсэлт 3-ын 60-70 см, зүсэлт 45-ийн 70-80 см-ын (тэгшдүү газрын дээр карбонаттай цайвар хүрэн хөрс) гүнээс авсан дээжүүдэд тодорхойлуулж (“Инженер геодези” ХХК-ийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори, дугаар 25/540) доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт 9. Хөрсний хүнд металлын агууламжийг хүлцэх хэмжээтэй харьцуулсан хэмжээ

Говийн бор хөрс,	Зэс (Cu) мг/кг	Кадмий (Cd) мг/кг	Хар тугалга (Pb) мг/кг	Хром (Cr) мг/кг	Никель (Ni) мг/кг	Цайр (Zn) мг/кг
Гурвансайхан, Өлзийт сумын толгодын чулуурхаг нимгэн цайвар хүрэн хөрс (h-1; 5),						
Дээжийн гүн, 0-20 см	3.54	байхгүй	1.85	байхгүй	8.39	79.43
Гурвансайхан ба Өлзийт сумдын хуурай хээрийн тэгшдүү тал газрын цайвар хүрэн хөрс (h 2;4; 7)						
Говийн бор хөрс	Зэс (Cu) мг/кг	Кадмий (Cd) мг/кг	Хар тугалга (Pb) мг/кг	Хром (Cr) мг/кг	Никель (Ni) мг/кг	Цайр (Zn) мг/кг
Дээжийн гүн, 22-32 см	6.27	байхгүй	1.57	байхгүй	9.79	80.74
Дээжийн гүн, 60-70 см	3.8	байхгүй	12.79	0.3	12.35	72.36
Дээжийн гүн, 70-80 см	9.51	байхгүй	5.25	12.71	28.3	111.28
MNS 5850:2019	100	3	100	150	150	300
Хүлцэх хэмжээнээс дахин бага	10-28	байхгүй	7-63	11	12-17	2-4

Шинжилгээний үр дүнгээс харахад байгалийн тогтцоор байгаа хөрсөнд Кадмий (Cd) илрээгүй. Хар тугалга (Pb) 7-63 дахин бага, Хром (Cr) 0-30 см-ын гүнд илрээгүй бөгөөд харин 70-80 см-ын гүнд илэрсэн боловч хүлцэх хэмжээнээс 11 дахин бага, Цайр (Zn) 2-4 дахин бага, Зэс (Cu) 10-28 дахин бага, никель (Ni) 12-17 дахин бага тус тус байна. Өөрөөр хэлбэл, хөрсөнд хүнд металлын ямар ч бохирдол байхгүй байна.

2.4. Ургамлан бүрхэвч

Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумдын нутагт орших “Саншайн Энержи Майнинг” ХХК-ийн MV-022599 тоот тусгай зөвшөөрөлтэй “Цагаан дэл” хэмээх 5029.70 гектар бүхий жоншны уурхайн ашиглалтын талбай нь д.т.д. 1100-1300 метрийн өндөрт байх бөгөөд өмнөд болон хойд хэсгээр говийн бэсрэг уулс, ухаа гүвээ толгодын ландшафт зонхилох ба багагүй хэсгийг хөндий, хоолой тал газар эзэлнэ. Эдэлбэр газрын толгодын ар хажуу хэсгээр харгана-алаг өвс ургамлын бүлгэмдэлтэй, харин тал хөндийн хэсгээр маш сийрэг алаг өвст, хотос хонхроор дэрс-хиагт, дэрс-улалжит хээрийн ургамалжил зонхилно.

Судалгаа явуулсан талбайн ургамалжилтын үндсэн хэвшинж, бүлгэмдэл:

Бэсрэг уулс, толгодын хээр: Судалгаа явуулсан талбайн хэсэг нь бэсрэг уулс, толгодын оройн, дунд хэсгээр хялгана-шарилж-харганат (*Stipa glareosa*, *Artemisia frigida*, *Caragana leucophloea*, *Allium polyrrhizum*, *Caragana pygmaea*, *Agropyron cristatum*, *Iris lactea*) хээр, харгана-хялгана-агьт (*Artemisia frigida*, *Stipa gobica*, *Iris lactea*, *Caragana leucophloea*, *C. pygmaea*, *Amygdalus pedunculata*, *Stipa grands*, *Allium mongolicum*, *Salsola collina*) хээр, үетэн-харгана-шарилжид (*Stipa gobica*, *Artemisia pectinata*, *A. frigida*, *Caragana leucophloea*, *Allium polyrrhizum*, *Caragana pygmaea*, *Agropyron cristatum*, *Iris lactea*, *Stelleria dichotoma*, *Achnatherum splendens*) хуурай хээр тохиолдоно. Ургамалжилтын тусгагийн бүрхэц 25-30%, зүйлийн бүрэлдэхүүнээрээ харьцангуй сайн 100 м² талбайд 18-20 зүйл ургамал тархана.



Зураг 5. Талын бэсрэг уул, толгодын ургамалжлын бүлгэмдэл

Хуурай хээр: Харгана-хялгана-агьт (*Artemisia frigida*, *Caragana pygmaea*, *Stipa gobica*, *Iris lactea*, *Caragana leucophloea*, *Stipa baicalensis*, *Allium polyrrhizum*, *Agropyron cristatum*) хээр, дэрс-хялганат (*Achnatherum splendens*, *Stipa gobica*, *Artemisia frigida*, *Iris lactea*, *Caragana leucophloea*, *Stipa grands*, *Allium polyrrhizum*, *Agropyron cristatum*) хөндий зэрэг нь судалгаа явуулсан нутгийн төв хэсэгт энэ бүлгэмдэл зонхилно. Ургамалжилтын тусгагийн бүрхэц 25-35%, зүйлийн бүрэлдэхүүнээрээ харьцангуй сайн 100 м² талбайд 12- 15 зүйл ургамалтай.



Зураг 6. Хуурай хээрийн ургамалжлын бүлгэмдэл

2.5. Амьтны аймаг

Тус газарт саарал чоно, тарвага байхгүй, цагаан зээр, шар үнэг, хярс ховор тархалттай. Учир нь нэгдүгээрт: тал нутаг ба малчдын өвөлжөө хаваржааны газар, хоёрдугаарт: зэргэлдээ орших уурхайн тэсэлгээ, олборлолт, тээвэрлэлт явагдаж байгаа учраас хүн, техникийн хөл хөдөлгөөн

ихтэй нутаг (Гурвансайхан ба Өлзийт сумдын танилцуулга, Дундговь аймгийн тайлан мэдээ (2015-2022) болон ард иргэдийн аман мэдээ) байна.

Үнэг, хярс ховор тархсан болохыг мөр, амьдардаг нүх мөн ард иргэдийн аман мэдээ, аймгийн ан амьтдын тайлан зэрэг материалаар тодорхой байна. Тухайлбал, 10 км² буюу 1000 га талбайд Шар үнэгний нягтшил 0.01-0.05 ш, хярс 1-3 ш байна (танилцуулгууд, тайлан мэдээ, аман мэдээ, өөрийн ажигласан үл мөр, амьтдын орогносон нүх зэргийг үндэслэж тооцоолов). Дашрамд дурьдахад амьтны судалгаа хийж байсан үед бид нартай нэг үнэг тааралдав.

Дулааны улиралд хярсны гол хоол тэжээл болох монгол чичүүл, үхэр огдой зэрэг өвс идэшт жижиг амьтад мөн л ховор байгаа байдал ажиглагдаж байна. Тухайлбал, монгол чичүүл, түүний нүх нэг га талбайд 2-4 ш тоологдож байна. Үүнээс үзэхэд үлийн цагаан огтоно нягтшил “бага” байна. Ер нь эл отгоны хувьд Монголын хуурай хээрийн бүс нутагт өргөн тархсан амьтан. Талбай орчим газарт эл отгоны тоо толгой сүүлийн жилүүдэд буурч байгаа байдал ажиглагдаж байна. Туулай хэлбэртэн амьтнаас бор туулай нөлөөллийн 3 бүсэд ховор байна. Харин дулааны улирал эхэлж байгаа учраас хонин гүрвэл элбэг байна.

Өвсөн тэжээлт туруутан амьтдаас цагаан зээр нүүдлийн шинж чанартай өөрөөр хэлбэл хавар ба намрын улиралд 5-10 бодгаль, заримдаа 30 хүртэл тоогоор хааяа дайран өнгөрдөг тохиолдол тааралддаг тухай орон нутгийн малчид ярьж байна.

Шувуудын хувьд индемик гарал үүсэлтэй тарважи бүргэд, талын сар, хар хэрээ, шаазгай, улаан хошуу зэрэг шувууд намхан уулс, тал хөндий, малчдын өвөлжөө, хаваржаа, намаржаа зэрэг газарт 3-7 бодгалиар үзэгдэж байна.

Тас, Таравжи бүргэд, сар, харцага зэрэг шувууд нь голчлон үлийн цагаан оготно болон бусад жижиг мэрэгч амьтнаар хооллодог. Судалгаа хийх үед дээр дурьдсан шувуу болон хар хэрээ, шаазгай, улаан хошуу зэрэг шувууд нь намхан уулс, малчдын өвөлжөө (малчид өвөлжөөнөөс нүүгээгүй байна) орчимд 1-3 бодгалиар тохиолдож байна. Тэдгээр шувууд нь намхан уулс, тодгод гүвээ, тал хөндий мөн суурин газар, малчин айл, хашаа саравч орчим газрын экологийн тэнцвэрт байдлыг зохицуулж хадгалж байна. Малчин айлын гадаа болон ойролцоо хэрээ, улаан хошуут болон шаазгай 2-4 ш байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын хэвлий, агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг юм.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 10. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х		х					
Гадаргын урсцын өөрчлөлт			х		х					
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х	х		
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтцын өөрчлөлт	х				х		х	х		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		х							х	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	х				х				х	
Бэлчээрийн байдал			х		х					
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х				х	
Эрчим хүчний нөөц	х				х				х	
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х		х					
Гадаргын усны чанар хэмжээ			х		х					
Агаарын бохирдол			х		х					
Хөрсний бохирдол			х		х					
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			х		х					
Дуу чимээ, шуугианы нөлөө		х			х					х

4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	х				х				х	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х				х	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			х		х					
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			х		х					
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			х		х					
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		+			+					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх	+				+				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			х		х					
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	+				+					+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+					+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+					+
Ажлын байр нэмэгдэх	+				+					+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+					+
7. Бусад нөлөөлөл										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			х		х					
Дүн	14	4	13	0	30	0	3	3	8	7

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Уурхайн олборлолт үйл ажиллагааны улмаар хөрс хуулах, олборлолт зэргээс хөрсөн бүрхэвч ухагдаж, ургамлан нөмрөг талхлагдаж урт хугацаанд шууд хүчтэй нөлөөлнө;
- Уурхайн олборлолтын ажлын улмаас геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр шууд урт хугацаанд дунд зэрэг нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;
- Ордын олборлолтын үйл ажиллагааны үр дүнд дуу чимээ нь шууд бусаар урт хугацаанд сөргөөр нөлөөлнө;

Богино хугацааны нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагааны явцад дуу чимээ тодорхой хугацаагаар ихэснэ.

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хөрс болон ургамлан, геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Хүснэгт 11. Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
1. Эдэлбэр газарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах	
Газрын нэгдсэн санд үзүүлэх нөлөө	Төслийг ТЭЗҮ-д заасан хугацаанд хэрэгжүүлж дуусгах
Бэлчээрийн ашиглалтад үзүүлэх нөлөө	Нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу хийж төлөвлөсөн хугацаанд орон нутагт хүлээлгэн өгөх
Газрын гадаргуу эвдэрч талхлагдах	Орчны гадаргуутай ландшафтын хэлбэршлийн хувьд нэгдмэл бүтэц бий болгоход анхаарах.
2. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах	
Шимт хөрсний үе давхаргад үзүүлэх нөлөө	Төсөл хэрэгжүүлэгч нь “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалант” MNS 5916:2008 стандартын дагуу хуулан авч хадгалах, нөхөн сэргээлтэд стандартын дагуу ашиглах.
3. Агаарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах	
Машин механизмаас ялгарах хорт хий, утаанаас үүсэх бохирдлын нөлөө	Машин механизмын утаанаас агаарт ялгарах хорт хийн хэмжээг бууруулах арга хэмжээ авах, ашиглаж буй машин техникт үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх, шаардлагатай хяналтыг үйл ажиллагаандаа хэвшүүлэх байдлаар хэрэгжүүлэх;
Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөн, бүтээгдэхүүн тээвэрлэж буй машинаас үүсэж болох шороо тоосноос агаарт тоосжилт үүсэх	Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайнуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах. Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулна
Шохойн чулуу тээвэрлэх болон ачих буулгах, шатаах зуухны үйл ажиллагаанаас үүсэх тоосны бохирдлын нөлөө	Төслийн үйл ажиллагаанаас ашиглалтын явцад машин техникийг тогтоосон замаар явуулж, ашиглахаа больсон замыг хааж, нөхөн сэргээх Хөрсний овоолгыг зонхилох салхины доод талд байгуулах мөн шатаах зуухны орчимд агаарын чанарын мониторингийн цэг байгуулах,
Ахуйн хог хаягдал, бохир ус, бие засах газрын ашиглалтаас үүсэх орчны бохирдлын нөлөө	Бие засах газар, хатуу хог хаягдлыг хадгалах сав, шингэн хаягдлын цооног зэрэгт мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгэх, хатуу хаягдлын цэг байгуулах, ариун цэврийн бүс тогтоох;
